

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС “ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

**Дорноговь аймаг Замын-Үүд сум
2024 он**

1. Үнэлгээний зорилго

- 1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн нэгдүгээр хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.
- 1.3. Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилд 2 –оос доошгүй удаа тооцно.
- 1.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 1.5. Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээллэнэ.

2. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10		
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		
5	Эрсдэлийн удирдлага	8	6		
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	7		

8	Компанийн соёл	6	6		
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		
	Нэгдсэн дүн	72	67		

3. Үнэлгээний аргачлал

3.1. Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.

3.2. Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

3.2.1. авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;

3.2.2. 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;

3.2.3. 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;

3.2.4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

Компанийн засаглалын үнэлгээний асуулга

Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	Хэрэгжсэн. Нотолгоог хавсаргав. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 7 бүлгийн 7.4 дэх ТУЗ-ын даргын хариуцах үйл ажиллагаа хэсгийн 7.4.12-т ТУЗ-аас хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвөлгөөг ямар тохиолдолд авахыг тодорхой зааж өгсөн заалтыг нэмж тусган ТУЗ-аар батлуулан мөрдөж ажиллаж байна.	2	100%
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	Хэрэгжсэн.	ТУЗ-ын гишүүдийг сонгох, томилох асуудлыг “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”, “Нэр дэвшүүлэх хорооны журам”-аас гадна “ТУЗ-ын гишүүдийг сонгох, нэр дэвшүүлэх журам”-аар зохицуулж байна. Үүнээс гадна ТУЗ-ын гишүүдийн залгамж халааны бодлогын баримт бичгийг 2022 онд батлан үйл ажиллагаандаа ашиглаж байгаа болно.	2	100%
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туриллага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</i>	Зарим асуудал хэрэгжсэн.	ТУЗ болон түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, үнэлэх журмыг ТУЗ-ийн гишүүдэд хүргүүлэн өөрийгөө болон бусад ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагааг үнэлүүлэхээр хүргүүлээд байна. ТУЗ-ийн гишүүдийн талаарх мэдээллийг үйл ажиллагааны тайлан мэдээлэлд байнга тусган ажиллаж байгаа болно.	1	50%
4	<i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туриллагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>	Хэрэгжсэн. Нотолгоог хавсаргав. Нэр дэвшүүлэх хорооны журам	ТУЗ-ийн бүрэлдэхүүний аль нэг хүйсийн эзлэх хувийг гучаас доошгүй байх талаар ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны 2-р бүлэг Хорооны чиг үүрэг хэсгийн 2.1.2-д шинээр нэмж тусган ТУЗ-д танилцуулан батлуулан мөрдөж ажиллаж байгаа ба 2023 онд ТУЗ-д ажиллах гишүүдийн	2	100%

			хүйсийн харьцаа 11,1% байна. Цаашид нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах болно.		
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	Зарим асуудал хэрэгжиж байгаа. Сургалтын төлөвлөгөө	2023 онд ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагааны нөхцөл байдлаас шалтгаалан сургалт хийгдээгүй байна. 2024 онд ТУЗ-ийн гишүүдэд зориулсан сургалтын төлөвлөгөө хуваарийг гаргасан.	1	50%
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Хэрэгжсэн.	ТУЗ-ийн нарийн бичгийн хариуцлагын асуудлыг Компанийн тухай хууль болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн нарийн бичгийн үйл ажиллагааны журмуудаар зохицуулж байна.	2	100%
ДҮН				10	83,3%
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ					
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	Хэрэгжсэн. Нотолгоог хавсаргав. Нэр дэвшүүлэх хорооны журам	ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг цаашлаад олонх нь хараат бус байх талаар ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны 2-р бүлэг Хорооны чиг үүрэг хэсгийн 2.1.2-д шинээр нэмж тусган ТУЗ-д танилцуулан батлуулан ажиллаж байна.	2	100%
8	<i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Хэрэгжсэн. Нотолгоог хавсаргав. ТУЗ-ын 2023 оны 04 тоот тогтоол	Аудитын хороо нь үйл ажиллагаагаа хорооны үйл ажиллагааны журмын дагуу явуулдаг ба үүнээс гадна шинээр Дотоод аудитын заавар, Дотоод хяналтын заавар зэрэг заавар журмуудыг баталж үйл ажиллагаандаа ашиглаж байна. ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 04 тоот тогтоолоор Аудитын хорооны даргаар хараат бус гишүүн Ж.Энхтулгыг томилсон. 2024 онд ажиллах ТУЗ-ийн хороод батлагдсан даруйд тогтоол болон бусад шаардлагатай бичиг баримтыг хүргүүлж ажиллах болно.	2	100%
9	<i>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i>	Хэрэгжсэн. Нотолгоог хавсаргав. ТУЗ-ын 2023 оны 04 тоот тогтоол	Цалин урамшууллын хороо нь үйл ажиллагаагаа хорооны үйл ажиллагааны журмын дагуу явуулдаг ба шинээр цалин урамшууллын бодлогын баримт бичгийг батлуулан мөрдөж ажиллаж байна. ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 04	2	100%

	<i>Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>		тоот тогтоолоор Цалин урамшууллын хорооны даргаар хараат бус гишүүн Х.Батхишгийг томилсон. 2024 онд ажиллах ТУЗ-ийн хороод батлагдсан даруйд тогтоол болон бусад шаардлагатай бичиг баримтыг хүргүүлж ажиллах болно.		
10	<i>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i>	Хэрэгжсэн. Нотолгоог хавсаргав. ТУЗ-ын 2023 оны 04 тоот тогтоол	Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагаа нь хорооны үйл ажиллагааны журмын дагуу явуулдаг ба шинээр ТУЗ-ийн гишүүдийг сонгох, нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлого зэрэг бичиг баримтыг батлан үйл ажиллагаандаа хэрэглэж байна. ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 04 тоот тогтоолоор Нэр дэвшүүлэх хорооны даргаар хараат бус гишүүн Ч.Оргилыг томилсон. 2024 онд ажиллах ТУЗ-ийн хороод батлагдсан даруйд тогтоол болон бусад шаардлагатай бичиг баримтыг хүргүүлж ажиллах болно.	2	100%
11	<i>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i>	Хэрэгжсэн.	Одоогоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд байнгын болон бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороо байхгүй байна. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тусгайлсан чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулах асуудал яригдах болно.	2	100%
ДҮН				10	100%
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
15	<i>3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Хэрэгжсэн. Нотолгоог хавсаргав. Мэдээллийн үйл ажиллагааны журам	Компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын талаарх “ Мэдээллийн үйл ажиллагааны журам “-ыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 11 сарын 20 өдрийн 14/10 тоот тогтоолоор батлан үйл ажиллагаандаа ашиглаж байна.	2	100%
16	<i>3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>	Хэрэгжсэн. Линк: https://www.etr.mn/Legal	Цахим хуудсанд компанийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ашиглаж байгаа засаглалын баримт бичиг, дүрэм, журам, заавруудыг бүрэн оруулж нэмэлт өөрчлөлт орсон даруйд шинээр оруулан олон нийтэд хүргэж байгаа ба	2	100%

			өнөөдрийн байдлаар нийт 23 заавар, журам, хөтөлбөр оруулсан байна.		
17	<i>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</i>	Хэрэгжсэн.	Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тодорхой, бодитой байхаар шийдвэрлэж тайлагнаж байгаа ба компанийн тайлагналыг аль болох хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нарт ойлгомжтой хүртээмжтэй байхаар үйл ажиллагаанд нөлөөлж байгаа гадна, дотно хүчин зүйл, эрсдэл зэргийг бүрэн багтааж байхаар боловсруулан хувьцаа эзэмшигчдэд МХБ, өөрийн цахим хуудсаар танилцууж байна.	2	100%
ДҮН				6	100%
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	<i>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Хэрэгжсэн.	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой хамтран ажиллах талаар тусгайлсан бүлэг оруулж хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломж нөхцөлөөр хангаж ажиллаж байна.	2	100%
16	<i>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</i>	Хэрэгжсэн.	Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох нөхцөлөөр хангаж байгаа бөгөөд 2023 оны хувьцаа эзэмшигчдийн хурал цахимаар зохион байгуулахад аудиторт хурлын зарыг хүргэж ажилласан бөгөөд тус компанийн санхүүгийн тайланд аудит хийсэн “ Их хөлөг монгол “ аудитын компанийн ахлах аудитор Г.Ариунбат хуралд оролцож аудитын тайланг танилцуулж мэдээлэл өгсөн.	2	100%
17	<i>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.</i>	Хэрэгжсэн. Нотолгоог хавсаргав. Гүйцэтгэх захирлын 2008 оны А/11 тоот тушаал	Дотоод хяналт шалгалтын нэгжийг 2008 оны 09 сарын 18-ний өдрийн А/11 тоот тушаалаар батлан журмын хавсралтаар компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан гаргасан. Журмаар нэгжийн үйл ажиллагаа чиг үүргийг	2	100%

			зохицуулсан бөгөөд мэдээллийг цахим хуудсанд байрлуулсан болно.		
ДҮН				6	100%
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	<i>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Зарим асуудал хэрэгжиж байгаа.	Компанийн эрсдэлийн удирдлагыг эрсдэлийн удирдлагын заавар, үйл ажиллагааны журам болон дотоод журмуудад заасан хэм хэмжээний хүрээнд хэрэгжүүлж ажиллаж байгаа ба одоогоор эрсдэлийн удирдлагын бүтэц байхгүй.	1	50%
19	<i>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>	Хэрэгжсэн.	Компанийн хувьд эрсдэлийн удирдлагыг өнөөдрийн байдлаар компанийн аудитын хороо хяналт тавьж ажиллаж байгаа ба жижиг компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлд эрсдэлийн удирдлага хариуцсан тусдаа хороо байх шаардлагагүй гэж шийдвэрлэсэн болно. Эрсдэлийн талаар түүнийг хэрхэн удирдаж байгаа талаар компанийн үйл ажиллагааны тайлан, цахим хуудас зэргээр дамжуулан нийтэд мэдээлж байгаа болно.	2	100%
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>	Хэрэгжсэн.	Хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэлийн түвшин ямар байгаа талаар компанийн хяналт шалгалтын нэгжээс анхан шатны үнэлгээг хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Зайлшгүй тусгай мэдлэг шаардагдах үйл ажиллагаанд хийгдэх эрсдэлийн үнэлгээг үнэлгээний компаниудаар хийлгэж танилцуулах болно.	2	100%
21	<i>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Зарим асуудал хэрэгжиж байгаа.	Комплайнсын хяналтын зааварыг баталж мөрдөн ажиллаж байгаа бөгөөд жижиг хувьцаат компанийн хувьд ийм бүтэцтэй байх шаардлагагүй гэж үзэж байгаа болно.	1	50%
ДҮН				6	75%
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					

22	<i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Хэрэгжсэн.	ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллын асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулж хэлэлцүүлдэг. Өнөөдрийн байдлаар компанийн санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой байдлын үүднээс ТУЗ-ын гишүүдэд цалин урамшууллын асуудал олгох, түүний хэлбэр, давтамжтай холбоотой асуудлыг ярилцаж эхлээгүй байгаа болно.	2	100%
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</i>	Хэрэгжсэн.	Компанийн эрх бүхий ажилтнуудын болон нийт ажилчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг цалин урамшууллын бодлогод тусган хэрэгжүүлэхээр цалин урамшууллын системийг бүрэн шинэчлэх талаар ажлуудыг зохион байгуулж байгаа ба хийгдсэн даруйд зохих бичиг баримтыг хүргүүлэх болно.	2	100%
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>	Хэрэгжсэн.	Компанийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн үйл ажиллагааны тайланд тусгаж байгаа болно. Гүйцэтгэх удирдлагад олгож байгаа цалин урамшуулал түүнийг олгох шалгуур үзүүлэлтийг шинээр боловсруулан ажиллаж байгаа ба 2024 оны хагас жилийн үйл ажиллагааны тайланд тусгах чиглэл барин ажиллаж байна.	2	100%
ДҮН				6	100%
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	<i>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>	Хэрэгжсэн.	“ Компанийн засаглалын кодекс “-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шаардлагатай бичиг баримтуудыг боловсруулан ТУЗ-д хүргүүлэн батлуулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.	2	100%
26	<i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>	Зарим асуудал хэрэгжсэн.	Үйл ажиллагааны тайлан болон бизнес төлөвлөгөөндөө хэрхэн ажиллаж байгаа болон ажиллах талаараа тусгаж ажиллаж байна.	1	50%

27	<i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>	Хэрэгжсэн.	Цахим хуудас хэвийн ажиллаж байгаа бөгөөд шаардлагатай цэсүүдийг нэмж үйл ажиллагааг нь байнга шалгаж, шинэчлэлт хийж ажиллаж байна.	2	100%
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	Хэрэгжсэн.	Ажилчдын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх болон ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, сургаж боловсруулах зэрэг асуудлыг компанийн дотоод журамд бүрэн дүүрэн тусгасан.	2	100%
ДҮН				7	87,5%
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Хэрэгжсэн. Нотолгоог хавсаргав. Ёс зүйн дүрэм	Компанийн ёс зүйн дүрмийг 2024 онд зарим зүйл заалт нэмэн дахин батлан гаргаж ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах болон ёс зүйн дүрэм зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон журмыг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.	2	100%
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i>	Хэрэгжсэн. Нотолгоог хавсаргав. Ёс зүйн дүрмийг хянан шийдвэрлэх журам	Компанийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журмын 3.2-т шинээр заалт нэмж тусган ажиллаж байна.	2	100%
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>	Хэрэгжсэн. Нотолгоог хавсаргав. Ёс зүйн дүрэм	Авилга, албан тушаалын гэмт хэргээс ангид байх талаар компанийн ёс зүйн дүрэмд тусдаа зүйл, хэсэг орсон ба улс төрийн үйл ажиллагааны тухай Компанийн ёс зүйн дүрмийн 5.3.6-д шинээр заалт нэмж тусган баталгаажуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	2	100%
ДҮН				6	100%
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	<i>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</i>	Хэрэгжсэн.	Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас болон компанийн цахим хуудсаар мэдээллээ тогтмол оруулж байна.	2	100%

33	<p>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</p>	Хэрэгжсэн.	<p>Компанийн фэйсбүүк хуудсыг тогтмол ажиллуулж компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэж ажиллаж байна. Үүнээс гадна цахим хуудсанд хөрөнгө оруулагчдад зориулсан цэсийг гарган компанитай холбоотой санхүү, үйл ажиллагааны тайлан, ТУЗ, ХЭХ-ын шийдвэрүүдийг тухай бүрд нь оруулж байхаар шинэчлэлт хийлгэсэн. Үлгэрчилсэн журмын дагуу хөрөнгө оруулагч нартай харилцах хөтөлбөрийг боловсруулан ТУЗ-д хүргүүлэн батлуулан ажиллаж байна.</p>	2	100%
34	<p>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</p>	Хэрэгжсэн.	<p>Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаа эзэмшигчдэд хурлыг зар хүргэх журам”-ын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 оны ХЭХ-ыг “БиДиСек ҮЦК” ХК-ийн цахим хурлын системээр дамжуулан хуралдуулсан. Энэ нь хөрөнгө оруулагчдыг өргөнөөр оролцуулах, мэдээллийг хүртээмтэй хүргэхэд чиглэсэн арга хэмжээ байсан ба цахим хурал нь жижиг хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаанд шууд оролцоход ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.</p>	2	100%
35	<p>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</p>	Хэрэгжсэн.	<p>Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаа эзэмшигчдэд хурлыг зар хүргэх журам”-ын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. Цаашид компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлуудыг хэлэлцэхээр бол ХЭ-ийг санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь анхаарч ажиллах болно.</p>	2	100%
36	<p>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</p>	Хэрэгжсэн.	<p>Ашиг сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй талаар компанийн үйл ажиллагааны тайлангуудад тогтмол мэдээлж байгаа бөгөөд сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх талаарх журмыг боловсруулан төлөөлөн удирдах</p>	2	100%

		зөвлөлд хүргүүлэн шийдвэрлүүлсэн ба үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.		
ДҮН			10	100%
НЭГДСЭН ДҮН			67	93,0%